

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ХБОБЗГД-ЫН ДАРГА

/ Б.БУЯННЭМЭХ /

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

ТӨСЛИЙН БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ

"ЖИНСИЙН ОРОЙ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ



/ М.ГЭРЭЛТ-ОД /

**“ДУЛААНЫ ТАЛ УСЛАЛТЫН СИСТЕМИЙГ СЭРГЭЭН
ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ” ТӨСЛИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН
АЖЛЫН ҮЕИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2679663/

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

/П.ШИНЭЦЭЦЭГ /

БОЛОВСРУУЛСАН:

"ЖИНСИЙН ОРОЙ" ХХК-ИЙН

БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖИЛТАН

/Э.НАНДИН-ЭРДЭНЭ/

УЛААНБААТАР ХОТ

2024 ОН

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Төслийн нэр	2
1.2. Төслийн зорилго	2
1.3. Төсөл хэрэгжүүлэгчдийн нэр, хаяг	2
1.4. Төслийн байршил	2
1.5. Төслийн төлөвлөлт, хүчин чадал.....	4
1.6. Түүхий эд, туслах материал	9
1.6.1. Үндсэн түүхийэн үхий эд, туслах материал ралтын ү	9
1.6.2. Ус хангамж, хэрэглээ	9
1.6.3. Цахилгаан эрчим хүчний хангамж.....	9
1.6.4. Дулаан хангамж	9
1.7. Хог хаягдал	9
ХОЕР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	14
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	23
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
АРВАН ХОЁР. 2024 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ	27
АРВАН ГУРАВ. ДҮГНЭЛТ	27

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Дулааны тал усалалтын системийг сэргээн засварлах” төслийн барилга угсралтын ажлын үеийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ-2024)

1.2. Төслийн зорилго


Энэхүү төслийн үндсэн зорилго нь “Дулааны тал” усалалтын системийг сэргээн засварлах замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, усалгааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, нутагшуулах, ногоочид, тариаланчдын чадавхи, орлогыг нэмэгдүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, шинээр ажлын байр бий болгоход оршино.

1.3. Төсөл хэрэгжүүлэгчдийн нэр, хаяг

Төслийн захиалагч:	Монгол Улсын Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)
Улсын бүртгэлийн дугаар:	9070003115
Регистрийн дугаар:	9132287
Хаяг:	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 3Г-ын 9-р байр
Утас:	452554, 456955
Төсөл хэрэгжүүлэгч:	Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл
Улсын бүртгэлийн дугаар:	9069001088
Регистрийн дугаар:	6610935
Хаяг:	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Хоршоологчдын холбооны байр, 511 тоот
Утас:	99117994
Төслийн санхүүжүүлэгч:	Азийн Хөгжлийн банк (АХБ)
Төслийн барилгын ажил гүйцэтгэгч:	“Жинсийн орой” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011195016
Регистрийн дугаар:	2679663
Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Гэрэгэ тауэр, 303
Утас:	77110746, 99087173

1.4. Төслийн байршил

“Дулааны талын усалалтын систем” төслийн талбай нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт байрлах ба Улаанбаатар хотоос зүүн зүгт 350 орчим км, Хэнтий аймгийн төв Чингис хотоос зүүн зүгт 6 орчим километр зайд, Хэрлэн голоор зааглагдаж урд талаараа Баянхутаг сумтай хил залган оршино. Талбайн хэмжээ нь 700.0 га.



Зураг 1. “Дулааны тал” усалтын системийн төсөл хэрэгжих талбайн байршил

Усалтын системийн талбайн эргэлтийн цэгүүдийн координатыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн эргэлтийн цэгүүдийн координат

Д.Д	Уртраг	Өргөрөг	Д.Д	Уртраг	Өргөрөг
1	110° 44' 39.909" E	47° 22' 5.442" N	22	110° 44' 40.742" E	47° 20' 33.696" N
2	110° 45' 57.876" E	47° 21' 6.208" N	23	110° 44' 35.902" E	47° 20' 23.933" N
3	110° 45' 49.878" E	47° 21' 4.031" N	24	110° 44' 29.914" E	47° 20' 24.536" N
4	110° 45' 36.863" E	47° 21' 6.415" N	25	110° 44' 24.464" E	47° 20' 25.704" N
5	110° 45' 28.497" E	47° 21' 5.828" N	26	110° 44' 20.733" E	47° 20' 25.393" N
6	110° 45' 24.413" E	47° 21' 3.947" N	27	110° 44' 17.785" E	47° 20' 23.888" N
7	110° 45' 20.392" E	47° 21' 0.260" N	28	110° 44' 15.227" E	47° 20' 22.927" N
8	110° 45' 19.316" E	47° 20' 55.917" N	29	110° 44' 14.524" E	47° 20' 20.919" N
9	110° 45' 15.483" E	47° 20' 38.444" N	30	110° 44' 15.045" E	47° 20' 17.306" N
10	110° 45' 13.069" E	47° 20' 36.875" N	31	110° 44' 17.485" E	47° 20' 13.778" N
11	110° 45' 12.741" E	47° 20' 34.090" N	32	110° 44' 17.388" E	47° 20' 13.648" N
12	110° 45' 7.794" E	47° 20' 33.722" N	33	110° 44' 13.806" E	47° 20' 8.409" N
13	110° 45' 6.547" E	47° 20' 36.093" N	34	110° 44' 8.864" E	47° 20' 8.282" N
14	110° 45' 1.153" E	47° 20' 41.081" N	35	110° 43' 12.620" E	47° 20' 2.947" N
15	110° 44' 55.018" E	47° 20' 44.776" N	36	110° 42' 53.684" E	47° 20' 11.683" N
16	110° 44' 51.489" E	47° 20' 45.205" N	37	110° 42' 44.586" E	47° 20' 12.587" N
17	110° 44' 47.485" E	47° 20' 44.504" N	38	110° 42' 44.436" E	47° 20' 12.521" N
18	110° 44' 44.050" E	47° 20' 42.365" N	39	110° 42' 36.460" E	47° 20' 9.285" N
19	110° 44' 42.019" E	47° 20' 39.585" N	40	110° 42' 22.069" E	47° 20' 1.930" N
20	110° 44' 40.933" E	47° 20' 37.501" N	41	110° 41' 50.197" E	47° 20' 25.764" N
21	110° 44' 41.114" E	47° 20' 33.696" N			


1.5. Төслийн төлөвлөлт, хүчин чадал

Энэхүү төсөл нь 2021-2026 он хүртэл 2 үе шаттай хэрэгжинэ. Үүнд:

1. Услалтын системийн барилгын ажил (Услалтын системийн толгойн барилга, усан сангийн барилга байгууламжийг шинэчлэн барих, усалгааны тоног төхөөрөмжийг угсрах, ус татах, дамжуулах хоолойг суурилуулах г.м); 2022-2023 он
2. Услалтын системийг ашиглалтанд хүлээн авч 700 га талбайд үр тариа, төмс, хүнсний ногоог усалгаатай тариалах; 2023-2026 он

Хүснэгт 2. Төслийн төлөвлөлт

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо
1	Усны эх булаг		Хэрлэн гол
2	Усалгаанд авах зарцуулга	м³/сек	0.360
3	Услах системийн талбай	га	Бороожуулах усалгаатай
	Энгийн усалгаатай		
4	Ус татамжийн барилга, Q=1.50 м³/сек	шир	1
5	Тунгаагуур, W=2500 м³	шир	1
6	Насос станц, Q х Н=480 кВт	шир	1
7	Угаалтын суваг	ум	900
8	Гол хоолой (D500 мм, HDPE)	ум	462
9	Хуваарилах хоолой D400-500 мм, HDPE)	ум	4134
10	Усалгааны хоолой D180-355 мм, HDPE)	ум	7703
11	Бороожуулах машин 75 га 490 м	шир	6
12	Бороожуулах машин 38га 350 м	шир	2
13	Бороожуулах машин 28га 300 м	шир	2
14	Бороожуулах машин 20га 250 м	шир	1
15	Хуваарилах худаг	шир	15
16	Юүлэх худаг	шир	11
17	Гидрант	шир	6
18	Вантузтай худаг	шир	6
19	Ашиглалтын зам	км	12.4
20	Ойн зурвас	км	3
21	Хамгаалалтын торон хашаа	км	14.2



Зураг 2. Услагын системийн ерөнхий төлөвлөгөө

“Дулааны тал” усалтын системийн ажлын зураг төсөлд тусгасаны дагуу дараах барилга байгууламжуудыг барихаар төлөвлөж байна. Үүнд:

- Ус авах барилга
- Насос станц
- Усалтын далд сүлжээ
- Бороожуулах машин зэрэг үндсэн болон туслах барилга байгууламж, тоног төхөөрөмжийг суурилуулахаар ажлын зурагт тусгасан байна.

Ус авах барилга:

Ус авах барилга нь Хэрлэн голоос усалгааны усыг авах зориулалт бүхий ил хийцтэй, эргийн ус татамжийн барилга болно. Ус авах барилга нь эргийн бэхэлгээ, понур, ус халиах босго, тунгаагуур болон аванкамераас бүрдэнэ.

Понур нь ус авах барилгын өмнө байрлах цутгамал төмөр бетон хийцтэй, хэвтээ байрлалтай хавтан бөгөөд ус авах барилгаруу орох усны урсгалыг жигд болгох, голын ёроолын хагшаас (элс шороо) орохоос хамгаалах зориулалттай. Понурын тэмдэгт ус халиах босгоны тэмдэгтээс 0.20 м доор байна. Ус халиах босго нь тус бүрдээ 1.0 м өргөнтэй 3 алслал бүхий өргөн босгот ус халиагуур байна. Ус халиах босгоны тэмдэгт ▼1060.80 м. Энэ нь голын усны түвшин хамгийн бага байх үеийн тэмдэгтээс 0.50 м доор байгаа болно. Голоос авах усны зарцуулгыг тохируулах, өвлийн улиралд бүрэн хааж ус авах барилгыг усгүй байлгах зориулалтаар ус халиах босгыг шандорон хаалттайгаар төлөвлөсөн болно.

Аванкамер нь насос станцийн хэвийн ажиллагааг хангахуйц усны эзлэхүүн болон түвшинг бүрдүүлэх зориулалттай ил хэлбэрийн хашлага хана бүхий байгууламж болно. Аван камерийн нийт урт 7.0 м, төгсгөл хэсэгтээ голын усны түвшин хамгийн бага байх үед аван камерт 1.20 м гүнтэй устай байхаар төслөгдсөн байна. Аван камер нь тус бүрдээ хамар ханаар тусгаарлагдсан 4 секцтэй, хог барих болон загас хамгаалах тортой бөгөөд дээрээ ашиглалтын гүүртэй.

Насос станц:

Насос станц нь Хэрлэн голоос (Ус татамжийн барилгаас) усалгааны усыг D500 мм диаметртай хоолойгоор шахаж услагдах талбайд хүргэнэ. Насос станцын хүчин чадлыг ус авах ба хүргэх газрын өндрийн зөрүү, нэг зэрэг ажиллах бороожуулах машины тоо, усалгаанд авах усны тооцоот зарцуулга, ус дамжуулах шугамын урт, гидравликийн үзүүлэлтэд тулгуурлан тогтоосон болно. Насос станцид ижил төрлийн 4 ш насос суурилагдах бөгөөд бүгд зэрэгцээ ажиллах боломжтой. Нэг насосын бүтээмж 90 л/с, шаардлагат түрэлт 70.0 м байх бөгөөд аль ч брендийн насос сонгогдохоос үл хамаарч энэ үзүүлэлтийг хатуу бармтлана.

Насос станцын барилга нь тэнхлэгээрээ 15x7.5 м хэмжээтэй, төмөр бетон шугаман суурьтай, бетон шалтай сендвичэн барилга байна. Станцын барилгын дотор ажлы насоснуудаас гадна монтажны талбай, операторын өрөө, цахилгааны шит, удирдлагын самбар байрлана.

Усалтын далд сүлжээ:

Усалтын далд сүлжээ нь 180-500 мм хүртэл диаметртай HDPE хуванцар хоолойгоос бүрдэнэ. Далд сүлжээний хоолойн нийт урт 12299 м. Хоолойн уртын дагууд тооцоот зарцуулгаасаа хамаарч хоолойн диаметр өөрчлөгдөх бол хоолойн ханын зузаан өөрчлөгдөхгүй.

Одоогоор усалтын систем дээр газар тариалан эрхэлж байгаа хувь хүн, аж ахуйн нэгжийн усалгааны усны хэрэгцээг хангах зориулалтаар 3 ш усалгааны далд хоолой, 6 ш ус авах гидрантыг төсөлд тусгаж өгсөн болно.

Бороожуулах машин:

Услалтын системд төвийн эргэлттэй нийт 11 ш бороожуулах машин суурилагдана. Үүний зургаа нь 490 м, хоёр нь 350 м, хоёр нь 300 м, нэг 200 м урттай байх бөгөөд бороожуулах усалгаанд хамрагдах нийт талбай 602 га. Бороожуулах машинуудын гуравны хоёр нь нэг зэрэг ажиллах техникийн боломж бүрдсэн бөгөөд энэ үед усалгаанд 360 л/с зарцуулга шаардагдана. Бороожуулах машины усалгаа хийж бүтэн тойрох хугацаа усалгааны нормоосоо хамаарч 3-4 хоног байна.

Усалгааны ажлыг бүрэн механикжуулах, автоматжуулах боломжтой, талбайн тэгшилгээг төдийлэн шаарддаггүй, усалгааг бага нормоор шуурхай зохион байгуулах боломжтой зэргийг харгалзан БНХАУ-н YULIN IRRIGATION компанийн “Center pivot irrigation” машиныг сонгосон. Энэхүү бороожуулах машин нь далд сүлжээн дээрх хөдөлгөөнгүй гидрантаас усаа авч тойргоор явж усалгааг хийдэг бөгөөд дэлхийн олон оронд ижил төрлийн хийц загварууд нь өргөнөөр ашиглагдаж байна.



Зураг 3. Төвийн тулгуурт бороожуулах машин

Бороожуулах машин техникийн үндсэн үзүүлэлт:

• Услах талбай, га	63.5
• Зарцуулга, л/с	65.0 (234 м ³ /ц)
• Бороожуулах машины урт, м	490
• Тэргэнцэр хоорондын зай, м	54.4 м
• Бороожуулах машины төгсгөлд байх даралт, МПа	0.30
• Борооны эрчим, м/мин	0.4

Услалтын далд сүлжээн дээрх барилгууд:

Услалтын системийн хэвийн ажиллагааг хангах зориулалтаар услалтын далд сүлжээн дээр хуваарилах худаг 15 ш , юүлэх худаг 11 ш , вантузтай худаг бш тус тус баригдана.

Хамгаалалтын хашаа:

Услалтын системийн талбайг тойруулан нийт 14.2 км урт торон хашаа баригдана. Торон хашаа 10*10 тортой дээгүүрээ өргөстэй утастай, 12-15 см диаметртэй модон шонтой байна.

Барилга, угсралтын ажил гүйцэтгэлийн 2022-2023 онуудад хийгдсэн ажлууд:

- Барилгын ажилд хэрэглэх түр тогны техникийн нөхцөлийн дагуу холболт хийгдсэн;
- Кемпийн тохижилтийн ажил;
- Улаан шугам;
- Хамгаалалтын торон хашаа 14км төлөвлөгдсөнөөс 12 км торон хашаа хийгдсэн;
- Ус татамжийн барилгын ажлын аванкамерийн узель, угаалтын сувгийн барилга угсралтын ажил хийгдэж дууссан;
- Усалгааны хоолойн угсралт, гол хоолойн угсралт 4км хийгдсэн;
- Хуваарилах худгуудын угсралт зүүн хэсгийн 11 худаг;
- Толгойн барилгын цутгамал хана, гаралтын сувгийн бетоны ажил;
- Толгойн барилгын тунгаагуурын хавтан цутгалт, угсралт;
- Насос станцын барилгын суурь, насосны суурь;
- Эргийн бэхэлгээний суурь;
- Усалгааны хоолойн угсралт;
- Худгуудын угсралт, тоноглол;
- Бороожуулагч машины хөдөлгөөнгүй суурь 10ш;

Нийт гүйцэтгэлийн хувь 72%

Барилга, угсралтын ажил гүйцэтгэлийн 2024 оны төлөвлөгөө

Хүснэгт 3. 2024 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө

№	Хийгдэх ажлын нэр	Ажил эхлэх дуусах хугацаа /Сар/
1	Үлдсэн бороожуулах машин тээвэрлэн төслийн талбайд буулгах	4.01-5.01
2	Үлдсэн бороожуулах машин угсрах, суурилуулах	4.01-7.01
3	Туршилт тохируулгын ажил	7.01-09.21
4	Химийн бодисын агуулах	6.1-6.28
5	Усны чанарын хяналтын 2 цооног гаргах	7.1-7.15
6	Техникийн комисс ажлуулах / гүйцэтгэгч, захиалагч, зургийн автор/	8.1-8.7
7	Техникийн комиссын өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах	8.7-9.15
8	Улсын комисс ажлуулах	9.15-9.27
9	Улсын комиссын үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах	9.15-9.27
10	Холбогдох бичиг баримтуудыг улсын архивт хүлээлгэн өгөх	9.15-9.27

Барилга угсралтын ажлын үед ашиглах техник, тоног төхөөрөмж

Услалтын системийн барилга угсралтын ажлын үед ашиглах машин механизм, техник тоног төхөөрөмжүүдийг Хүснэгт 4-т үзүүлэв. Машин механизмын зогсоолын талбайг төв замтай ойр услалтын системийн талбайн зүүн хойд хэсэгт байрлуулсан.

Хүснэгт 4. Услалтын системийн барилга угсралтын үед ашиглах техник, тоног төхөөрөмжүүд

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк, төрөл	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Хүчин чадал
1	Дугуйт экскаватор	Hyundai R145	1	м ³	0.7
2	Авто кран	Hyundai mighty 5ton	1	тн	5
3	Ачааны машин	портер	1	тн	2
4	Ковш	XCMG	1	м ²	2

1.6. Түүхий эд, туслах материал

1.6.1. Үндсэн түүхийэн үхий эд, туслах материал ралтын ү

Барилга угсралтын үндсэн материал болох бетон зуурмаг, хэв хашмал зэрэг материалуудыг дотоодын зах зээлээс хангахаар төлөвлөсөн. Харин услалтын системийн үндсэн тоног төхөөрөмжүүд болох бороожуулах машин, гол болон хуваарилах хоолой, усалгааны хоолой бусад туслах материалуудыг Хятад улсаас импортлон ашиглаж байна.

1.6.2. Ус хангамж, хэрэглээ

Барилгын ажлын үед ажиллах нийт ажилчдын унд, ахуйн ус хэрэглээг төслийн талбайтай ойр орших сумын гүний худгаас зөврөөр хангах ба хоногт 1.5 м³ ус хэрэглэнэ.

1.6.3. Цахилгаан эрчим хүчний хангамж

Төсөл хэрэгжих талбай нь сумын төвд байрлах тул Сумын ЗДТГ болон бусад холбогдох байгууллагатай зөвшилцөж, зөвшөөрөл авсны үндсэн дээр батлагдсан техникийн нөхцөлийн дагуу барилгын ажилд ашиглах түр тог авсан.

1.6.4. Дулаан хангамж

Барилгын ажлыг зөвхөн дулааны улиралд явуулах тул дулаан хангамжийн эх үүсвэрт холбогдох шаардлагагүй болно.

1.7. Хог хаягдал

Услалтын системийн барилгын ажлын үед дараах төрлийн хог хаягдал үүснэ. Үүнд:

- Ахуйн хатуу, шингэн хаягдал
- Барилгын материалын хаягдал
- Технологийн хаягдал (Машин механизм, техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнээс гарах хаягдал)

Ажилчдын тооноос хамааран хоногт 15 кг орчим ахуйн хатуу хаягдал, 2-2.5 м³ орчим ахуйн шингэн хаягдал үүснэ.

ХОЕР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Монголын Дорнод талын их муж, Халхын дундад ба Дарьгангын талархаг мужын Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт хамаарагдах ба далайн түвшнээс дээш 10191023 метрийн өндөрт өргөгдсөн. Баруун хойд талаараа 1100 метрийн өндөрт өргөгдсөн Цогт уулаар, хойд талаараа 1150 м өндөрт өргөгдсөн Самбаллүндэв уулсаар хүрээлэгдэн, Хэрлэн голын эргийн дагуу Хэрлэн дулааны хөндийд оршдог.

Газрын гадаргын хувьд Хэрлэн голын татмын дээрх нам дэнж болох тэгш гадаргуу бүхий хөндийд байрлах бөгөөд хойноосоо урагшаа ялимгүй хэвгий тогтоцтой. Хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд Хэрлэн голын татмын дээрх дэнжийн өндөр 1.0-1.5 метр, налуу нь 0.25-0.5 град, өргөн нь 1.5-3.5 км орчим байна.

Температур: Хэнтий аймгийн нийт нутаг дэвсгэр хотгор гүдгэрийн ялгаа ихтэй учраас өвөл зуны температурын хэлбэлзэл их байна. Аймгийн жилийн дундаж агаарын температур нь +20 ...-20С -ийн хооронд тэгш хэмтэй хэлбэлзэнэ. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын дундаж температур -18-24⁰С хүйтэн байх боловч газрын гадаргын өндөр намаас хамааран газар бүрт харилцан адилгүй байна. Хэрлэн сумын нутгаар 1 дүгээр сарын дундаж температур -23.7⁰С, хамгийн дулаандаа -0.5⁰С, хамгийн хүйтэндээ -44.3⁰С байдаг.

Жилийн хамгийн дулаан 7 дугаар сард тус сумын нутгаар дундаж температур 20.2⁰С, хамгийн их нь 41.0⁰С, хамгийн бага нь 4.6⁰С хүрдэг байна.

Агаарын температурын хоногийн хамгийн их температур нь аль ч улиралд 1415 цагийн үед ажиглагддаг бөгөөд харин хамгийн бага нь жилийн улирлын байдлаас шалтгаалж 5-8 цагийн хооронд хэлбэлздэг ажээ. Тухайлбал өвлийн улиралд өглөөний 7-8 цаг үед, хавар намрын улиралд 6 цагийн үед, зун 4-5 цагийн үед тус тус ажиглагддаг байна.

Хөрсний гадаргын температурын тухайд 1 дүгээр сард дундаж температур - 21⁰С, 7 дугаар сард дундаж температур 26.5⁰С байдаг. Хэрлэн суманд анхны цочир хүйтрэл дунджаар 9 сарын 12-нд, хамгийн эртдээ дунджаар 8 сарын 26-нд, хамгийн оройдоо дунджаар 9 сарын 26-нд болдог бол хавар дунджаар 5 дугаар сарын 27-нд, хамгийн эртдээ 5 сарын 8-нд, хамгийн оройдоо 6 сарын 16 цочир хүйтрэл ажиглагддаг байна. Хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа тус суманд 101-114 хоног байдаг байна.

Агаарын чийг, хур тунадас: Хэнтий аймгийн хойд хэсэг чийглэгдүү, өмнөд хэсэг нь хуурайвтар хэсгээр ялгагдана. Судалгаанаас үзэхэд өндөр уулын бүсэд 400 мм, ойт хээрийн бүсэд 300-400 мм, хээрийн бүсэд 200-300 мм, нутгийн өмнөд хэсэг цөлөрхөг хээрийн бүсэд 200 мм-с бага тунадас ордог. Хур тунадасны хоногийн явцыг авч үзвэл өдрийн хугацаанд шөнийн хугацаанаас харьцангуй илүү тунадас ордог. Энэ нь агаарын урсгал шөнө харьцангуй тогтвортой байдагтай холбоотой.

Аймгийн нутагт анхны цас нутгийн уулархаг бүсэд 8 дугаар сарын 3 дугаар арав хоногт бусад нутагт 9 дүгээр сарын 1 дүгээр арав хоногт орох ба тогтвортой цасан бүрхүүл ихэнх нутгаар 10 дугаар сүүлээр тогтох ба нутгийн хойд хэсгээр 4 дүгээр сарын эхний арав хоногт, бусад нутгаар 3 дугаар сарын 2 дугаар арав хоногт арилж нийтдээ 85-101 хоног цасан бүрхүүлтэй байдаг байна.

Нарын цацрагийн горим: Хэнтий аймгийн нутгаар жилд дунджаар 2770-3056 цаг нар гийгүүлдэг. Нар гийгүүлэх хугацаа 12 дугаар сард хамгийн бага 137-192 цаг, 6 дугаар сард хамгийн их 267-295 цаг болно. Энэ нь 6 дугаар сард нарны өндөр хамгийн их, 12 дугаар сард хамгийн бага байдагтай холбоотой. Сарын туршид нар гийгүүлэх хугацаа нь 5 дугаар сард

7 дугаар сарыг бодвол 7-24 цагаар илүү байдаг нь зуны дунд сард үүлшил нэлээд их болдогтой холбоотой.

Салхи: Салхины горим нь агаар мандлын ерөнхий орчил урсгал, тухайн орон нутгийн уул зүйн онцлогоос шалтгаална. Салхины дундаж хурдны их утга аль ч бүс нутагт хавар 4-5 дугаар сард тохиолдох бөгөөд нутгийн хойд уулархаг хэсгээр 2.8-4.0 м/с, бусад хэсгээр 4.5-6.0 м/с байдаг. Тус аймгийн нутагт баруун өмнөөс баруун хойд зовхисын салхи зонхилох боловч цаг уурын өртөө харуулын орчны хотгор гүдгэрийн байдлаас болж газар бүр өвөрмөц байдаг.

Аймгийн нийт нутгаар жилд дунджаар 34 өдөр шороон шуурга шуурдаг бол 24 өдөр нь цасан шуургатай байдаг.

“Дулааны тал” усалтын системийн төслийн талбай нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт байрлана.

Агаарын чанарын өнөөгийн байдал: Усгалтын системийн талбай нь Хэнтий аймгийн төв Чингис хот буюу Хэрлэн сумын нутаг дэвсгэрт байрладаг.

Агаарын чанарын харуулын ажиглалт, хэмжилтийн дүнгээс харахад агаар дахь хүхэрлэг хийн (SO_2) дундаж агууламж нь 0.008мг/м^3 , хамгийн их тодорхойлогдсон агууламж нь 0.012мг/м^3 , хамгийн бага агууламж нь 0.005мг/м^3 байсан байна. Харин азотын давхар ислийн (NO_2) дундаж агууламж нь 0.010мг/м^3 , хамгийн их агууламж 0.021мг/м^3 , хамгийн бага агууламж нь 0.002мг/м^3 байсан нь MNS4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давж бохирдсон тохиолдол гараагүй байна. Агаарын чанарын индексийн үнэлгээгээр хэвийн түвшинд байв.

Төсөл хэрэгжих талбайн орчны хөрсөн бүрхэвч, түүний онцлог: Хөрс газар зүйн мужлалаар Хангайн их мужийн өргөргийн бүсшилтэй нутгийн Хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүс Өндөрхаан-Түмэнцогтын тойрогт хамаарагдана (Монгол орны үндэсний атлас 2009). Хүрэн хөрс манай оронд хамгийн өргөн тархсан бөгөөд газар зүйн байрлал, гарал үүслийн хувьд нугат хээрийн хар шороон хөрснөөс цөл хээрийн бор хөрсөнд шилжих завсрын шинжтэй. Ийм хөрсөн дээрх ургамлан бүрхэвч тачир, агь, хялгана, үет ургамал голлох ба дээд үе давхаргын ялзмагийн хэмжээ 2.5 орчим хувь байна. Давсны хүчлийн нөлөөнд ихэвчлэн ялзмагт үеийн доороос буцлах боловч карбонатын хуримтлал 35-45 см-ийн гүнээс эхэлнэ. Механик бүрэлдэхүүн нь янз бүр, элсэнцэрээс хүнд шавранцар хүртэл тохиолдоно.

Төслийн талбайн ургамлан нөмрөгийн төлөв байдал: Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт орших төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дундад халхын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Энэ тойрогт 793 зүйл ургамалтай бөгөөд зөвхөн энэ тойрогт ургадаг 1 зүйлийн ургамалтай. Төслийн талбай болон тухайн орчны нутаг дэвсгэрт Сибирь хялгана, Крыловын хялгана, хиаг, дэрвээн хазаар өвс, саман дурваа, сунагар биелэг, саман ерхөг зэрэг үетэн оролцсон хялгана-дурваат, шивээт хялгана-шавагт, шивээт хялгана- хазаарганат, хиаг- шивээт хялганат хуурай хээр зонхилно.

Нутаг дэвсгэр: Хэрлэн сум /Чингис хот/ Хэнтийн нуруунаас эх авсан Хэрлэн голын ай сав бүхий тал хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1,631 м өндөрт оршдог. Нийт 380.8 мянган га нутаг дэвсгэртэй. Газар нутгийн 363.0 мянган га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, үүнээс 328,6 мянган га буюу 86.3 хувийг бэлчээрийн талбай эзэлдэг. Нийслэл Улаанбаатар хотоос 330 км зайд, хатуу хучилттай автозамаар холбогдсон, тээвэр холбоо, эрчим хүч зэрэг дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн хот юм. Мөрөн, Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Биндэр, Батноров, Баянхутаг зэрэг сумуудтай хил залгаа оршдог.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт хэрэгжихээр төлөвлөж буй “Дулааны тал” усалтын системийн төслийн барилга угсралтын ажлын үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдал, бүс нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, түүний эрчимшил зэргийг магадлан жагсааж, болзошгүй нөлөөллийг тодрууллаа.

Хүснэгт 5. Төслийн барилгын ажлын үед байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт								
Газрын доорх урсацын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй							
Газрын доорх усны чанарын өөрчлөлт		X		x				x
Гадаргын усны урсцын өөрчлөлт	x			x				x
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x			x	
Хөрсний элэгдэл,эвдрэл	X			x			x	
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		x		x				X
Геологийн тогтоцын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй							
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй							
2. Байгалийн нөөц, ашиглалт								
Газрын гадаргын нөөц баялаг	X			X				X
Бэлчээрийн байдал		x		X				x
Эрдэс түүхий эдийн нөөц	Нөлөөлөл байхгүй							
Эрчим хүчний нөөц	X			x				x
3. Байгаль, орчны өөрчлөлт								
Ундны усны чанар, хэмжээ	x			X				x
Хөрсний бохирдол	X			x			x	
Агаарын бохирдол		x		x				x
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x		x				x
Дуу чимээ, шуугианы нөлөө	x			x				x
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл								
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x			x				x
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x			x				x
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй							
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй							
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй							
5. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө								
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	x			x				x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x				x
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх	x			x				x
Татварын орлого өөрчлөгдөх		x		x				x
Ажлын байр нэмэгдэх	x			x				x
Дүн	13	7	0	20	0	0	3	17

Эдгээр болзошгүй нөлөөллүүдийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

Шууд бус нөлөөлөл: Нийт болзошгүй нөлөөллийн 7 (35%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Усралтын системийн барилгын ажлын явцад газрын доорх усны чанарын

өөрчлөлт, зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, бэлчээрийн байдал, хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх зэрэгт шууд бус сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй байна.

Шууд нөлөөлөл: Гадаргын усны урсцын өөрчлөлт, ургамлын бүтцийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, газрын гадаргын нөөц баялаг, ундны усны чанар, хэмжээ, хөрсний бохирдол зэрэг шууд сөрөг нөлөөллүүд гарч болзошгүй бөгөөд эдгээр нь нийт болзошгүй нөлөөллийн 13 (65%) - ийг нь эзэлж байна. Барилгын ажлын явцад үүсч болзошгүй нөлөөллүүдээс дурдвал:

- Барилгын ажлын явцад газрын гадарга, хөрсөн бүрхэвч эвдрэх, машин механизмын хөдөлгөөнөөр хөрс талхлагдан доройтох;
- Машин механизм, тээврийн хэрэгслийн зогсоолын талбай, ажилчдын түр кемпийн орчны хөрсөн бүрхэвч ахуйн болон техникийн хатуу, шингэн хаягдлаар бохирдох, хөрсний үржил шим доройтох, нянгийн болон хүнд металлын бохирдол үүсэх;
- Ургамлан нөмрөг талхлагдан доройтох, устах;
- Шороон зам талбайгаас тээврийн хэрэслийн хөдөлгөөн болон салхины нөлөөгөөр тоосжилт үүсэх;
- Машин механизмын дутуу шаталтат хөдөлгүүрээс хийн төлөвт бохирдуулагч ялгарах;
- Гадаргын ус ахуйн болон техникийн хаягдлаар бохирдох;
- Барилгын ажлын үед гадаргын усны урсцыг өөрчлөх, эргийн нуралт үүсэх;
- Гадаргын болон газрын доорх ус шатах тослох материалаар бохирдох;
- Дуу шуугианы бохирдол бий болох;
- ХАБЭА-н дүрэм журам зөрчигдөх, ажилчдын эрүүл мэндэд хохирол учруулах;

Нөлөөллийн хугацаа: Энэхүү төслийн барилга байгууламжийг төлөвлөсний дагуу богино хугацаанд барих тул нөлөөллийн үргэлжлэх хугацааг богино хугацаанд хамруулсан болно.

Нөлөөллийн эрчим: Нийт нөлөөллийн 15 хувь нь дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл, 65 хувь нь бага зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл байна. Харин орон нутгийн болон иргэдийн аж амьдрал, нийгэм эдийн засагт эерэгээр нөлөөлөх ба энэ нь нийт нөлөөллийн 20 хувийг эзэлж байна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Дулааны тал” услалтын системийн төслийн барилга угсралтын ажлын үеийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон 2021 онд батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэн боловсрууллаа.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь төслийн барилга, газар шорооны ажлын үйл ажиллагаанаас агаарт үүсгэж буй тоосжилт, хөрсний элэгдэл, доройтол, ургамлан нөмрөгийн доройтол, гадаргын болон газрын доорх усны нөөц, хатуу шингэн хог хаягдлаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.

2024 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд 54 260.0 (Тавин дөрөв хоёр зуун жаран мянга) төгрөг төлөвлөлөө.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Цаг уур, уур амьсгал									
1	Цаг уурын гэнэтийн, аюултай үзэгдлийн улмаас болзошгүй осол аваар гарах	Хэт халах, хүчтэй аадар бороо орох, хүчтэй салхилах, шороон шуурга шуурах, үер буух зэрэг байгаль цаг уурын аюултай үзэгдлийн үед барилга газар шорооны ажил болон материал тээвэрлэлтийн үйл ажиллагааг түр зогсоох, техник хэрэгслүүдийг унтрааж, ажиллагааг зогсоох	Төслийн талбайд	-	-	-	-	Барилгын ажлын явцад	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он □□Машин механизмуудын аюулгүй ажиллагааны дүрэм
2	Барилгын цаг уурын мэдээ ашиглаагүй, тохиромжгүй үед барилга, газар шорооны ажлыг явуулснаас барилгын чанарын норм стандарт алдагдах, эвдрэл гэмтэл гарах	Услалтын системийн барилга, газар шорооны ажлыг барилгын цаг уурын мэдээнд үндэслэн гүйцэтгэх, цаг уурын мэдээтэй уялдуулан ажлын төлөвлөгөө гаргах	Төслийн талбайд	-	-	-	-	Барилгын ажлын явцад	Монгол Улсын барилгын норм ба дүрэм, “БНБД 23-01-09 Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд” 2009 он

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ									
3	Материал тээвэрлэх болон бусад үйл ажиллагааны үед тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүсэх	Шороон зам дагууд замын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, санамж бүхий самбар байршуулж, нэг замаар зорчих нөхцөлийг бүрдүүлэх	Төслийн талбайд	ш	200.0	2	400.0	5 сард	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
4	Материал тээвэрлэх үед ачааны хэсгээс тоос үүсэх, асгарах	Барилгын материал тээвэрлэх үед аль болох битүү амбаартай машинаар тээвэрлэх, эсвэл хучлагаар хучиж тээвэрлэх	Төслийн талбайд	метр	200	3	600.0	Тээвэрлэлтийн явцад	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
Газрын гадарга хөрсөн нөлөөллөөс орчинд үзүүлэх сөрөг сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
